



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар A/02

Баян-Өндөр сум

Г

Ажлын хэсэг батлах тухай

Г


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын албан хаагчдын бүтэц орон тоо шинэчлэн батлагдсантай холбоотой "Албан тушаалын тодорхойлолт"-ыг дахин боловсруулах, хөдөлмөрийн гэрээг шинэчлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг холбогдох журамд нийцүүлэн боловсруулж, шинэчлэх саналыг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээний ахлах мэргэжилтэн (П.Хишгээ)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
01 сарын 15 өдрийн 1/02 тоот тушаалын хавсралт

Ажлын хэсгийн ахлагч:

Гишүүд:

Нарийн бичгийн дарга:

1. Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн
2. Эмнэлгийн тусламжийн чанар эргсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн
3. Эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч
4. Хяналт шинжилгээ үнэлгээний ахлах мэргэжилтэн
5. Эрүүл мэндийн боловсрол сургалт сурталчилгаа олон нийт хариуцсан ахлах мэргэжилтэн
6. Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
8. Эмнэлгийн дотоод халдвар хариуцсан мэргэжилтэн
9. Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан
10. Дархлаажуулалт, зоонозын асуудал хариуцсан мэргэжилтэн
11. Архив бичиг хэргийн ажилтан
12. Хүний нөөцийн төлөвлөлт хангалт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн